

Санхүүгийн хяналт шалгалт хийсэн
дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Булган аймгийн Засаг даргын баталсан 2018 оны 04 сарын 17-ны өдрийн 1/03 дугаар удирдамжийн дагуу Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулж, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун би 2018 оны 04 сарын 20-ны өдрөөс хуанлын 4 хоногт багтаан төлөвлөгөөт шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Баяннуур сумын “Моносхон” цэцэрлэгийн 2016, 2017 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Баяннуур сумын 1-р багт байрлах 9012281 регистрийн дугаартай “Моносхон” цэцэрлэг нь үндсэн 18 ажиллагсадтай ба үүнээс эрхлэгч 1, үндсэн багш 4, туслах багш 4, дуу хөгжмийн багш 1, тогооч 1, туслах тогооч 1, нярав бичиг хэргийн ажилтан 1, үйлчлэгч 1, галч 4 гэсэн орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулсан байна.

Зуны гэр цэцэрлэгийг 2016 онд 06 сарын 20-оос 07 сарын 21-нийг хүртэл 19 хоног 765 хүүхэд өдөр ажиллуулж 1266.1 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан ба үндсэн багшаар С.Цэнд-Аюуш, Н.Алтантуяа, туслах багш Ц.Эрдэнэчимэг, Г.Мөнх-Эрдэнэ, тогоочоор Б.Гандолгор, Ц.Ариунаа нар ажилласан байна.

2017 онд 06 сарын 20-оос 06 сарын 30-ныг хүртэл 20 хоног 869 хүүхэд өдөр ажиллуулж 1433.1 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан ба үндсэн багшаар Х.Цэрэннадмид, Н.Алтантуяа, туслах багш Н.Наранцэцэг, Ц.Эрдэнэчимэг, тогоочоор Б.Гандолгор, Д.Туяа нар ажилласан байна.

Шалгагдсан онуудад тус цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 1-р гарын үсгийг Л.Тунгалаг, 2-р гарын үсгийг Т.Ганчимэг нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100041515201 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041515401 дугаар, сумын ХААН банкинд байрших 5272071010 дугаар тус тус данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Тус байгууллагын няраваар 2016 оны 01 сарын 01-ээс 2017 оны 09 сарын 30-ны өдрийг хүртэл Б.Алтантуяа, 2017 оны 10 сарын 02-оос 10 сарын 30-ны өдрийг хүртэл Х.Мөнхзул, 2017 оны 10 сарын 02-оос 11 сарын 15-ны өдрийг хүртэл Д.Өрнөхдэлгэр, 2017 оны 11 сарын 16-аас 12 сарын 31-ний өдрийг хүртэл Н.Болормаа нар ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тус сумын цэцэрлэгийн 2016, 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тус цэцэрлэгийн **2016** оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитаар иргэдээс авсан хүнс материалын 9527.0 мянган төгрөгөөс ашгийн татвар 95.3 мянган төгрөг авсан ч төсөвт шилжүүлээгүй, хүнсний үнэ 30.0 мянган төгрөгийг илүү, 57.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн, тайланд авлага, өглөг үүсгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй нийт 182.8 мянган төгрөгийг төлүүлэхээр акт тогтоосон ба уг төлбөрийг барагдуулаагүй байна. Түлш халаалтын зардлаас 1300.0 мянган төгрөгөөр “Ихэр шагай” ХХК-аас материал бэлтгэсэн ба үүнээс 570.0 мянган төгрөгийн баримт тамга тэмдэггүй, иргэн Зоригтод шилжүүлсэн 1850.0 мянган төгрөгийн нүүрсийг орлогод авалгүй зарцуулсан зөрчлийг илрүүлж, арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгсөн ба 2018 оны 03 сард зөрчлийг бүрэн арилгасан байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тус цэцэрлэгийн **2017** оны санхүүгийн тайлангийн аудитаар иргэн С.Зоригтоос нүүрс худалдан авч тооцоог хийхдээ иргэний худалдан авсан дугуйны үнийг хасч ХХОАТатвар 74.0 мянган төгрөг дутуу суутгасан, нярав бичиг хэргийн ажилтаны орон тоонд ажилладаг Б.Алтантуяад эрхлэгчийн тушаалаар бичиг хэргийн ажлыг хавсруулан үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдэл цалин тооцож 1196.6 мянган төгрөг олгож батлагдсан орон тоо, төсвийг хэтрүүлэн зарцуулсанд 50 хувь болох 598.0 мянган төгрөгийг эргүүлэн төлүүлэхээр акт тогтоосон ба уг төлбөрийг барагдуулаагүй ба төлөх хугацаа болоогүй байна.

Дотоод хяналт шалгалтын талаар:

Тус сумын Санхүүгийн албанаас орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2017 он, 2018 оны эхний 2 сарын байдлаарх касс харилцахын баримт, агуулахын бүртгэл хөтлөлт, няравын анхан шатны баримтын бүрдэлт, хөтлөлтийн байдалд дотоодын хяналт шалгалтыг хийсэн ба уг шалгалтаар тус цэцэрлэгт бэлэн мөнгөний хүсэлтэд байгууллагын даргын цохолт дутуу, 108.9 мянган төгрөгийн интернетийн төлбөрийн нэхэмжлэх, зарлагын баримт байхгүй, ахмадад олгосон гарын бэлгийн жагсаалтад гарын үсэг зуруулаагүй, цалингийн урьдчилгаа

өргөдөлгүй, олгосон жагсаалтад гарын үсэг зурагдаагүй, 2 галчид цалингийн зөрүү олгосон анхан шатны баримт байхгүй, бүсийн урлаг, спортын наадмын шагнал олгохдоо жагсаалт үйлдээгүй, багш нарын баяраар зарцуулсан шагналд тавьж олгосон баримт үйлдээгүй байсан зөрчил илэрч уг зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг өгсөн байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Баяннуур сумын цэцэрлэгийн 2016, 2017 оны касс, харилцахын баримт, эрхлэгчийн тушаал, няравын хүнс, бараа материалын баримт, эд хөрөнгийн тооллогын бүртгэл, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, ажлын цагийн тооцоо, агуулахын бүртгэл, багшийн ирцийн бүртгэл, санхүүгийн тайлан, хөдөлмөрийн дотоод журам, бусад байгууллагаас болон дотоод хяналт хийсэн шалгалтын материал зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Л.Тунгалаг, нягтлан бодогч Т.Ганчимэг, нярав Б.Алтантуяа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2016 онд улсын төсвөөс 242696.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж батлагдсаны дагуу авсан, нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн хөгжлийн сангаас цэцэрлэгийн дээврийн засварт 5000.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжид 6639.7 мянган төгрөг нийт 254336.3 мянган өгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлыг 242696.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 154840.0 мянган төгрөг, тогтмол зардалд 25441.2 мянган төгрөг, нормативт зардалд 36897.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 6687.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 5166.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 100.4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 348.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 337.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1427.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 132.5 мянган төгрөг нийт 231377.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 16318.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төлөвлөгдсөн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 12342.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 3591.1 мянган төгрөг, хоол 345.4 мянган төгрөг, гэрэл цахилгаан 10.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 29.0 мянган төгрөг үлдсэн байна.

2017 онд улсын төсвөөс 237367.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж санхүүжилтийг бүрэн авсан, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсан эхийн тэтгэмж болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжид 5628.3 мянган төгрөг бүгд 242995.5 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлыг 237367.2 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 153300.7 мянган төгрөг, тогтмол зардалд 19732.5 мянган төгрөг, нормативт зардалд 28213.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5394.5 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаар 8703.0

мянган төгрөг, урсгал засварын зардалд 861.7 мянган төгрөг, албан томилолтын зардалд 99.4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 715.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 3237.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 5400.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5431.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 458.1 мянган төгрөг нийт 231547.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5819.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төлөвлөгдсөн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 3012.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 100.3 мянган төгрөг, түлш халаалт 1966.8 мянган төгрөг, хоол 724.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 15.0 мянган төгрөг үлдсэн байна.

Нэмэлт орлогын талаар:

Баяннуур сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварын зардалд зарцуулахаар Булган аймгийн Засаг даргын 2016 оны 06 сарын 03-ны А/268 дугаар захирамжийн дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд Орон нутгийн хөгжлийн сангаас 4500.0 мянган төгрөг, тус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 041552400 тоот дансанаас 2016 оны 07 сарын 26-нд цэцэрлэгийн ХААН банкинд байрших 5272071010 дугаар дансанд 5000.0 мянган төгрөг бүгд 9500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба тус байгууллагын 4 галчаар дээврийн засварын ажлыг гүйцэтгүүлж, галч нарын цалинд 2000.0 мянган төгрөгийг цэцэрлэгийн төсвөөс олгосон байна. Дээврийн засварын материалыг Улаанбаатар хотын Зуун айл БМДэлгүүрээс 9005.6 мянган төгрөгөөр бэлтгэсэн, материал тээвэрлэж авч ирсэн тээврийн хөлсөнд 495.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Цэцэрлэгийн дээврийн хуучин төмрийг сумын иргэдэд худалдаж нийт 933.5 мянган төгрөгийн орлого орсон, хүүхдүүдийн эцэг эхээс байгууллагын гаднах өнгө үзэмжийг сайжруулах дэмжлэг болгож бэлэн мөнгө 256.0 мянган төгрөг өгч нийт 1189.5 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс 483.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тушааж, үлдэгдэл 706.0 мянган төгрөгийг бүртгэлийн дансаар дамжуулалгүй шууд зарцуулсан байна. Уг мөнгөөр байгууллагын гаднах өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор Ихэр шагай ХХК-иас 15.5 мянган төгрөгөөр 15 ш блок, Жоби барилгын материалаын дэлгүүрээс 661.0 мянган төгрөгөөр 10 ш эмульс, 12 ш пегмент, 10 ш өнхрүүш, Зуун айл БМДэлгүүрээс 13.0 мянган төгрөгөөр 2 ш тасдагч ир, Их цагаан даваа БМДэлгүүрээс 50.0 мянган төгрөгөөр 6 ш өнхрүүш, 10 л будаг, 4 кг оохор, Улаанбаатар хотын БМДэлгүүрээс 483.5 мянган төгрөгөөр цемент, будаг худалдан авч зарцуулсан байна.

2017 оны 11 сард сумын малчин н.Бадам тус цэцэрлэгийн гаднах хаяг хийхэд дэмжлэг болгож 231.3 кг хонины мах хандивласан ба уг махыг байгууллагын ажилчид болон сумын 2 иргэнд нэг кг махыг 3000 төгрөгөөр тооцож 693.9 мянган төгрөгөөр худалдсан байна. Махны үнийг цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн 100041515402 тоот дансанд 2018 оны 01 сарын 15-нд 246.0 мянган төгрөг, 2018 оны 04 сарын 23-нд 447.9 мянган төгрөгийг тушаасан байна.

Тэтгэмжийн талаар:

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай таван жил ажилласан багш Д.Энхнаранд 2017 онд 3237.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

2016 онд жирэмсэн амаржсан 2 эхэд 6639.7 мянган төгрөгийн тэтгэмж олгосон бол 2017 онд хөдөлмөрийн чадвар түр алдсан 3 ажилтанд 583.0 мянган төгрөг, жирэмсэн, амаржсан 2 эхэд 5045.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон айна.

Үр дүнгийн урамшуулал, үр чадвар, шагналт цалингийн талаар:

Тус цэцэрлэгийн эрхлэгч Л.Тунгалагт Булган аймгийн Засаг даргын 2016 оны А/257, 2017 оны А/200, А/514 дугаар захирамжаар 2016 оны 6-12 сард үндсэн цалингийн 15 хувиар 667.9 мянган төгрөг, 2017 оны 01-12 сард 1393.9 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл цалин, Булган аймгийн Засаг даргын 2016 оны А/142, А/307, А/451, А/545 дугаар, 2017 оны А/238, А/391, А/512, А/634 захирамжаар 1-4-р улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 45 хувиар тооцож нийт 2560.4 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалин, Баяннуур сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 21-ний өдрийн Б/64, 2017 оны 12 сарын 22-ны өдрийн Б/53 дугаар захирамжаар сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр 2016 онд 90.6%, 2017 онд 90.4%-иар дүгнэгдсэн гэж 1 сарын үндсэн цалин буюу 1422.4 мянган төгрөгийн урамшуулалт цалин тус тус олгосон байна.

Тус сумын цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны Б/10, Б/16, Б/23, Б/33 дугаар тушаалуудыг үндэслэн багш, ажиллагсдад 1-4-р улиралд 13164.6 мянган төгрөг, 2017 оны Б/11, Б/20, Б/26, Б/45 дугаар тушаалуудыг үндэслэн багш, ажиллагсдад 1-4-р улиралд 13373.5 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар 2016 онд байгууллагын аварга, шилдэг ажилтнаар шалгарсан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын улсын үзлэгт хангалттай үнэлгээтэй шалгагдсан, аж ахуйн ажилд идэвхи санаачлагатай ажилласан, цэцэрлэгийн дээврийн төмрийг шинэчлэн сольсон, хичээлийн жилийн нэгдсэн тайлан бичилтээр тэргүүн байр эзэлсэн, улсын архив бичиг хэргийн шалгалт, улсын эд хөрөнгийн тооллогыг угтаж архивын өрөө, эд хөрөнгөд тооллого хийж цэгцэлсэн, багш нарын үр чадварын тэмцээнд тэргүүлж амжилттай оролцсон, 2016 оны эд хөрөнгийн тооллогоор сайн үнэлгээ авч үнэлүүлсэн гэж, 2017 онд байгууллагын шилдэг ажилтнаар шалгарсан, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор хангалттай сайн үнэлэгдсэн, багш олимпиадад амжилттай оролцож 3-р байр эзэлсэн, цэцэгжүүлэх аяны хүрээнд идэвхи санаачлагатай оролцож тэргүүн, дэд байр эзэлсэн, өөрийн хариуцсан үүрэгт ажлаа чанартай сайн гүйцэтгэж, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж ажилласан, 2017-2018 оны хичээлийн жилийн багш нарын үр чадварын уралдаанд амжилттай оролцож тэргүүн болон 2-р байр эзэлсэн, хүүхдийн авъяасыг нээн хөгжүүлэх ажилд идэвхитэй ажилласан гэж багш, ажиллагсдад үр чадварын нэмэгдэл болон шагналт цалин олгосон байна.

Тус цэцэрлэгийн багш, ажиллагсад 2017 оны 10-12 сарын цалингаас 3 өдрийн цалин 1078.95 мянган төгрөгийг Булган аймгийн 80 жилийн ойд хандивласан байна.

6.2 Өглөг, авлагын талаар: Байгууллагаас /сумын төрийн сан/ авах 2000.0 мянган төгрөгийн авлагатай. Өглөгийн хувьд шалгагдсан онуудад өглөггүй тайлан баланс гарсан байна.

6.3 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2017 онд нийт 149 мэдээлэл оруулахаас 134-г хугацаанд нь мэдээлж, 15 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

6.4. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

2016 оны эхний үлдэгдэл 338507.6 мянган төгрөгийн хөрөнгө дээр төсвийн хөрөнгө 899.7 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 2 ш суурин компьютер, 349.9 мянган төгрөгөөр принтер, 399.9 мянган төгрөгөөр өнгөт принтер, 849.8 мянган төгрөгөөр зөөврийн компьютер худалдан авсан, хүүхдүүдийн эцэг эхээс 1609.7 мянган төгрөгөөр 2 ш ус цэвэршүүлэгч, 1 ш өнгөт принтер, 2 ш зурагт, 1 ш тоос сорогч хандивлаж нийт 5008.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 12 сарын 14-ний Б/31 дүгээр тушаалаар элэгдэл болон ашиглалтын хугацаа дуусч шаардлага хангахгүй болсон 5 нэр төрлийн 6 ш 4239.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг актлан данс бүртгэлээс хасч, оны эцэст 339276.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2017 оны эхний үлдэгдэл 339276.7 мянган төгрөгийн хөрөнгө дээр төсвийн хөрөнгө 1498.2 мянган төгрөгийн 1 ш зөөврийн компьютер, 2135.6 мянган төгрөгөөр хөгжмийн зэмсэг, 399.8 мянган төгрөгөөр 2 ш микрофон, 544.8 мянган төгрөгөөр хөргөгч, 1319.8 мянган төгрөгөөр хөлдөөгч, 294.8 мянган төгрөгөөр угаалгын машин, 550.0 мянган төгрөгөөр аяга ариутгагч, 140.0 мянган төгрөгөөр тоос сорогч, 20.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 35 м дрож, 99.0 мянган төгрөгөөр 3 ш сандал, 240.0 мянган төгрөгөөр 3 ш ширээ, 240.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 3 ш ширээ, 145.0 мянган төгрөгөөр шургуулга, 152.0 мянган төгрөгийн цэцгийн тавиур нийт 8703.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 01 сарын 10-ны Б/01 дүгээр тушаалаар элэгдэл болон ашиглалтын хугацаа дуусч шаардлага хангахгүй болсон 11 нэр төрлийн 138 ш 5555.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, номыг актлан данс бүртгэлээс хасч, оны эцэст 342424.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

6.5. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

2016 оны эхний үлдэгдэл 31913.1 мянган төгрөг дээр 29.0 мянган төгрөгийн эм боох, 4621.1 мянган төгрөгийн аж ахуйн, 22076.7 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 33348.1 мянган төгрөг хүнсний материал худалдан авч, 55256.5 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 36742.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

2017 оны эхний үлдэгдэл 36742.5 мянган төгрөг дээр 16.3 мянган төгрөгийн эм боох, 5297.2 мянган төгрөгийн аж ахуйн, 80.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, 1778.3 мянган төгрөгийн шатахуун, 12508.7 мянган төгрөгийн мод нүүрс, 1160.0 мянган төгрөг мотор, 1200.0 мянган төгрөгийн нормын хувцас, 260.0 мянган төгрөгөөр насос, 424.9 мянган төгрөгийн бусад засварын 27658.2 мянган төгрөгийн хүнсний материал

худалдан авч, 61980.5 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 25125.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарчээ.

2017 оны 12 сард 3000 төгрөгөөр 307.9 кг хонины мах 923.7 мянган төгрөгөөр тус сумын Засаг даргын Тамгын газраас худалдан авч, хүнсний тайланд орлогодон хүүхдийн хоолонд зарцуулсан байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар багш, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор **2016 онд** багш П.Мөнхдэлгэр, туслах багш Н.Алтантуяа, Н.Наранцэцэг, Н.Оюунчимэг, галч Ө.Нэргүй нарт нийт 4.8 тн, **2017 онд** ахмад настан Б.Сүрэн, Уртнасан, Цэрэннадмид, туслах багш С.Цэнд-Аюуш, нярав бичиг хэргийн ажилтан Б.Алтантуяа нарт 5 тн, Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны 03 сарын 07-ны өдрийн 3/70 тоот албан бичгийн дагуу сумын цагдаагийн албан хаагчид 1 тн нүүрс тус тус олгосон байна. .

ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

- ✓ Хандив, тусламжаар ирсэн хөрөнгийг тухай бүрд данс бүртгэлд тусгасан.
- ✓ Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, зөрчилгүй тушаасан байна.
- ✓ Нягтлан бодогч Т.Ганчимэг нь багш П.Мөнхдэлгэрээс 2016 онд цалингийн урьдчилгаанд илүү суутгасан 150.0 мянган төгрөгийг 2017 оны 01 сард нөхөж олгосон, эрхлэгч Л.Тунгалагт 2017 оны 3-р улирлын урамшууллыг 42.7 мянган төгрөгөөр илүү олгосныг хянаж 10 сард буцаан суутгасан байна.

НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Сумын цагдаагийн албан хаагчид 1 тн нүүрс олгохдоо цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар бус тус сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны 03 сарын 07-ны өдрийн 3/70 тоот албан бичгийг үндэслэж сумын цагдаагийн албан хаагчид 1 тн нүүрс олгосон байна.
2. Нярав бичиг хэргийн ажилтан Б.Алтантуяагийн жирэмсэн, амаржсаны тэтгэмжтэй байх хугацаанд Д.Өрнөхдэлгэрийг няраваар авч ажиллуулсан ч ажилд томилсон тушаал байхгүй, Нярав Д.Өрнөхдэлгэрийг ажлаас чөлөөлж, Н.Болормааг няраваар томилж ажиллуулсан ба ажлаас чөлөөлөхдөө тушаал гаргаагүй байна.
3. Анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, бараа материалд агуулахын бүртгэл хөтлөөгүй, хүнсэнд агуулахын бүртгэл хөтөлсөн ч дутуу бүртгэж хөтөлсөн, хөтлөгдвөл зохих анхан шатны баримтуудаас бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт, үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт, тооцоо нийлсэн акт зэргийг үйлддэггүй.
4. Албан томилолтоор ажилласан албан хаагчдад томилолтын зардал байхгүй гэдэг шалтгаанаар албан томилолтын үнэмлэх олгодоггүй.
5. Байгууллагын дээврийн хуучин төмрийг худалдсанаас орсон орлого 450.0 мянган төгрөг, хүүхдүүдийн эцэг эхээс хандивласан 256.0 мянган төгрөг нийт 706.0

мянган төгрөгийн орлогыг байгууллагын бүртгэлийн дансаар дамжуулалгүй зарцуулсан.

6. Шилэн дансны мэдээллийн самбар 29.4 мянган төгрөгөөр хэвлүүлсэн ч одоог хүртэл тайланд орлогод авч данс бүртгэлд тусгаагүй байна.

7. Шатахууныг авсан хэмжээгээр зарцуулж, хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 1 албан шаардлага, улсын байцаагчийн актаар 3812.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Шалгалтын хугацаанд 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 393 дугаар тушаалаар баталсан журам, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг мөрдөж ажиллаагүй, шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих хяналт сул байна дүгнэлээ.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Сэлбэг шатахууны зардлын гүйцэтгэлд хяналт тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

